



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 534

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд орон сууцжуулахад шаардлагатай КТП, ТП барих” ажлын хүрээнд бий болсон нийт 299,771,924.00 (хоёр зуун ерэн есөн сая долоон зуун далан нэгэн мянга есөн зуун хорин дөрвөн) төгрөгийн балансын үнэ бүхий 2х630 кВа чадалтай дэд станцыг “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал В.Адъяа, Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Оюунгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132006278

28-r huraldaan.docx